

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

### Товчилсон үгсийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УБЦТС	Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ
ТӨХК	Төрийн өмчийн хувьцаат компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

## АГУУЛГА

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	5
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	15
3. Аудитын тайлан.....	16
3.1. Ерөнхий зүйл .....	16
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	16
3.4. Материаллаг байдал .....	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.9. Аудитын илрүүлэлт .....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал.....	21
татахуйц бусад чухал асуудлууд .....	21
4. Менежментийн захидал .....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	22



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ДҮРСЛЭХ УРЛАГИЙН  
МУЗЕЙН ЗАХИРАЛ  
П.БАЙГАЛМАА ТАНАА

2021.02.25 № 07/575  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дүрслэх урлагийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүрслэх урлагийн музейн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл 81.3 хувьтай тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

## Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>105,531,668.70</u></b>	<b><u>90,171,392.45</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>24,888,100.00</b>	<b>2,033,657.45</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,929,780.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	536,657.45
3351	Байгууллагаас авах авлага	22,958,320.00	1,497,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>80,643,568.70</b>	<b>88,137,735.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>80,643,568.70</b>	<b>88,137,735.00</b>
35410	Бичиг хэргийн материал	1,659,275.00	1,149,877.00
35420	Аж ахуйн материал	44,719,751.00	49,980,789.00
35440	Түлш, шатах тослох материал	1,195,420.00	978,410.00
35450	Барилгын засварын материал	00.00	5,386,780.00
35470	Бусад хангамжийн материал	33,069,122.70	30,641,879.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>27,874,413,671.56</u></b>	<b><u>27,804,198,582.63</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>27,874,413,671.56</b>	<b>27,804,198,582.63</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>27,786,782,971.56</b>	<b>27,716,777,882.63</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,014,405,900.00	1,014,405,900.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(71,293,843.08)	(142,587,686.16)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	7,850,000.00	7,850,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(7,850,000.00)	(7,850,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,655,863.15	243,155,663.15
39206	Хуримтлагдсан элэгдэл	(194,304,813.04)	(206,494,143.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	106,993,193.80	106,993,193.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(76,016,566.27)	(82,616,731.75)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	26,773,960,500.00	26,773,960,500.00
39217	Ном	9,382,737.00	9,961,187.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>87,630,700.00</b>	<b>87,420,700.00</b>
39301	Програм хангамж	1,225,000.00	1,225,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(437,500.00)	(647,500.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	86,843,200.00	86,843,200.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>27,979,945,340.26</u></b>	<b><u>27,894,369,975.08</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>180,000.00</u></b>	<b><u>18,960.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>180,000.00</b>	<b>18,960.00</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>180,000.00</b>	<b>18,960.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	18,960.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	180,000.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>27,979,765,340.26</u></b>	<b><u>27,894,351,015.08</u></b>

<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>27,979,765,340.26</b>	<b><u>27,894,351,015.08</u></b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,372,812,225.00	2,372,812,225.00
51101	Өмч: - төрийн	2,372,812,225.00	2,372,812,225.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>(127,361,155.26)</b>	<b>(212,775,480.44)</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	(127,361,155.26)	(127,361,155.26)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(85,414,325.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,734,314,270.52	25,734,314,270.52
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>27,979,945,340.26</u></b>	<b><u>27,894,369,975.08</u></b>



**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**  
2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>565,164,147.00</b>	<b>615,581,024.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>88,891.00</b>	<b>3,855,074.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	88,891.00	3,855,074.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	88,891.00	3,855,074.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>565,075,256.00</b>	<b>611,725,950.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>444,388,100.00</b>	<b>566,876,595.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	444,388,100.00	566,876,595.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>120,687,156.00</b>	<b>44,849,355.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	30,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,687,156.00	14,849,355.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>639,044,556.35</b>	<b>709,722,249.18</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>639,044,556.35</b>	<b>709,722,249.18</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>600,096,629.11</b>	<b>556,763,550.77</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>338,745,769.65</b>	<b>313,336,068.62</b>
210101	Үндсэн цалин	215,843,993.65	210,999,567.34
210102	Нэмэгдэл	44,271,798.00	61,375,311.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,733,200.00	34,243,509.37
210104	Урамшуулал	48,896,778.00	6,717,680.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,911,568.44</b>	<b>40,472,004.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,226,839.55	27,561,321.14
210202	Тэтгэмжийн даатгал	8,841,877.64	3,529,703.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,913,830.00	2,511,225.71
210204	Ажилгүйдлийн даатгал	314,721.00	624,523.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,614,300.25	6,245,230.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,719,505.44</b>	<b>22,211,657.12</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,494,396.03	9,055,240.70
210302	Түлш, халаалт	10,196,939.36	12,158,729.21
210303	Цэвэр, бохир ус	1,028,170.05	997,687.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,802,219.97</b>	<b>7,969,679.54</b>
210401	Бичиг хэрэг	1,263,415.00	884,300.00
210402	Тээвэр, шатахуун	968,344.00	1,006,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,445,073.67	2,166,566.54
210404	Ном, хэвлэл	117,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,752,168.00	2,424,664.00



Дүрслэх урлагийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,256,019.30	1,488,059.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1,659,140.00</b>	<b>2,007,828.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,659,140.00	2,007,828.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>24,983,243.00</b>	<b>7,686,254.55</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	181,500.00	-
210604	Урсгал засвар	24,801,743.00	7,686,254.55
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>12,387,560.00</b>	<b>-</b>
210701	Гадаад албан томилолт	10,714,960.00	-
210702	Дотоод албан томилолт	1,672,600.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>22,968,714.56</b>	<b>44,957,095.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,837,614.56	41,963,839.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,349,800.00	1,222,000.00
210807	Газрын төлбөр	563,220.00	563,220.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	55,800.00	57,636.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>125,918,908.05</b>	<b>118,122,963.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,428,100.00	27,508,924.70
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	320,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	107,490,808.05	90,293,338.93
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,947,927.24</b>	<b>152,958,698.41</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>31,381,959.24</b>	<b>-</b>
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,381,959.24	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,565,968.00</b>	<b>52,289,195.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,565,968.00	52,289,195.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>100,669,503.41</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	100,669,503.41
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(73,880,409.35)</b>	<b>(94,141,225.18)</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>-</b>	<b>8,726,900.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	-	8,726,900.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>8,726,900.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(73,880,409.35)</b>	<b>(85,414,325.18)</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**  
2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>565,171,256.00</u></b>	<b><u>620,425,635.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>565,171,256.00</b>	<b>620,425,635.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	444,388,100.00	566,876,595.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	444,388,100.00	566,876,595.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>120,783,156.00</b>	<b>53,549,040.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	30,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	120,783,156.00	23,549,040.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>550,055,242.00</u></b>	<b><u>603,460,885.00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>550,055,242.00</b>	<b>603,460,885.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>511,107,314.76</b>	<b>449,965,529.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>338,745,769.65</b>	<b>313,336,068.62</b>
210101	Үндсэн цалин	215,843,993.65	210,999,567.34
210102	Нэмэгдэл	44,271,798.00	61,375,311.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	29,733,200.00	34,243,509.37
210104	Урамшуулал	48,896,778.00	6,717,680.20
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,911,568.44</b>	<b>40,472,004.31</b>
210201	Тэтгэврийн даатгал	26,226,839.55	27,561,321.14
210202	Тэтгэмжийн даатгал	8,841,877.64	3,529,703.49
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,913,830.00	2,511,225.71
210204	Ажилгүйдлийн даатгал	314,721.00	624,523.07
210205	Эрүүл мэндийн даатгал	5,614,300.25	6,245,230.90
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,719,505.44</b>	<b>22,211,657.12</b>
210301	Гэрэл, цахилгаан	12,494,396.03	9,055,240.70
210302	Түлш, халаалт	10,196,939.36	12,158,729.21
210303	Цэвэр, бохир ус	1,028,170.05	997,687.21
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>9,304,563.67</b>	<b>8,988,824.54</b>
210401	Бичиг хэрэг	1,855,235.00	897,590.00
210402	Тээвэр, шатахуун	2,111,600.00	1,394,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,445,073.67	2,166,566.54
210404	Ном, хэвлэл	117,200.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,752,168.00	2,424,664.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,023,287.00	2,105,504.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,046,380.00</b>	<b>3,055,200.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,046,380.00	3,055,200.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>25,573,393.00</b>	<b>11,391,234.55</b>
210604	Урсгал засвар	25,573,393.00	11,391,234.55
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>14,317,340.00</b>	-
210701	Гадаад албан томилолт	12,644,740.00	-
210702	Дотоод албан томилолт	1,672,600.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>51,937,594.56</b>	<b>49,543,440.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,806,494.56	46,578,099.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	71,280.00	59,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00
210807	Газрын төлбөр	563,220.00	563,220.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	55,800.00	29,721.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	2,349,800.00	1,222,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,551,200.00</b>	<b>967,100.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	137,500.00	-
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,413,700.00	967,100.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>38,947,927.24</b>	<b>153,495,355.86</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	<b>31,381,959.24</b>	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	31,381,959.24	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>7,565,968.00</b>	<b>52,289,195.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,565,968.00	52,289,195.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	-
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	<b>101,206,160.86</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	100,669,503.41
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	536,657.45
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>15,116,014.00</u></b>	<b><u>16,964,750.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>15,116,014.00</b>	<b>16,964,750.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,116,014.00</b>	<b>16,964,750.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,116,014.00</b>	<b>16,964,750.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	15,116,014.00	16,964,750.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(15,116,014.00)</u></b>	<b><u>(16,964,750.00)</u></b>

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	2,372,812,225.00	25,734,314,270.52	(53,480,745.91)	<b>28,053,645,749.61</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,734,314,270.52</b>	<b>(53,480,745.91)</b>	<b>28,053,645,749.61</b>
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(73,880,409.35)	<b>(73,880,409.35)</b>
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,734,314,270.52</b>	<b>(127,361,155.26)</b>	<b>27,979,765,340.26</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,734,314,270.52</b>	<b>(127,361,155.26)</b>	<b>27,979,765,340.26</b>
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(85,414,325.18)	<b>(85,414,325.18)</b>
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,372,812,225.00</b>	<b>25,734,314,270.52</b>	<b>(212,775,480.44)</b>	<b>27,894,351,015.08</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>573,724,200.00</b>	<b>466,207,091.59</b>	<b>107,517,108.41</b>	<b>81.3</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>573,724,200.00</b>	<b>466,207,091.59</b>	<b>107,517,108.41</b>	<b>81.3</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>514,082,400.00</b>	<b>413,917,896.59</b>	<b>100,164,503.41</b>	<b>80.5</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>386,586,000.00</b>	<b>313,336,068.62</b>	<b>73,249,931.38</b>	<b>81.1</b>
210101	Үндсэн цалин	261,913,800.00	210,999,567.34	50,914,232.66	80.6
210102	Нэмэгдэл	98,483,500.00	61,375,311.71	37,108,188.29	62.3
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,037,700.00	34,243,509.37	(9,205,809.37)	136.7
210104	Урамшуулал	1,151,000.00	6,717,680.20	(5,566,680.20)	584.6
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>52,189,200.00</b>	<b>40,472,004.31</b>	<b>11,717,195.69</b>	<b>77.6</b>
210202	Тэтгэмжийн даатгал	3,865,900.00	3,529,703.49	336,196.51	91.3
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,092,700.00	2,511,225.71	581,474.29	81.2
210204	Ажилгүйдлийн даатгал	773,200.00	624,523.07	148,676.93	80.8
210205	Эрүүл мэндийн даатгал	7,731,700.00	6,245,230.90	1,486,469.10	80.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>23,624,600.00</b>	<b>22,211,657.12</b>	<b>1,412,942.88</b>	<b>94.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	11,691,400.00	9,055,240.70	2,636,159.30	77.5
210302	Түлш, халаалт	11,088,000.00	12,158,729.21	(1,070,729.21)	109.7
210303	Цэвэр, бохир ус	845,200.00	997,687.21	(152,487.21)	118.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>6,508,200.00</b>	<b>6,480,218.54</b>	<b>27,981.46</b>	<b>99.6</b>
210401	Бичиг хэрэг	922,200.00	897,590.00	24,610.00	97.3
210402	Тээвэр, шатахуун	1,194,500.00	1,194,500.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,547,800.00	1,547,566.54	233.46	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,649,300.00	1,649,300.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,194,400.00	1,191,262.00	3,138.00	99.7
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,084,000.00</b>	<b>3,055,200.00</b>	<b>28,800.00</b>	<b>99.1</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,084,000.00	3,055,200.00	28,800.00	99.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,270,600.00</b>	<b>2,265,630.00</b>	<b>4,970.00</b>	<b>99.8</b>
210604	Урсгал засвар	2,270,600.00	2,265,630.00	4,970.00	99.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>39,819,800.00</b>	<b>26,097,118.00</b>	<b>13,722,682.00</b>	<b>65.5</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,922,000.00	23,322,997.00	13,599,003.00	63.2
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,000,000.00	1,000,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	157,000.00	59,400.00	97,600.00	37.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,000.00	71,000.00	0.00	100.0

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,222,000.00	1,222,000.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	372,000.00	372,000.00	0.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	55,800.00	29,721.00	26,079.00	53.3
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>59,641,800.00</b>	<b>52,289,195.00</b>	<b>7,352,605.00</b>	<b>87.7</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>59,641,800.00</b>	<b>52,289,195.00</b>	<b>7,352,605.00</b>	<b>87.7</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	59,231,800.00	52,289,195.00	6,942,605.00	88.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,000.00	00.00	410,000.00	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>573,724,200.00</b>	<b>466,207,091.59</b>	<b>107,517,108.41</b>	<b>81.3</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>573,724,200.00</b>	<b>466,207,091.59</b>	<b>107,517,108.41</b>	<b>81.3</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	573,724,200.00	466,207,091.59	107,517,108.41	81.3
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>32</b>	<b>32</b>	<b>0</b>	<b>100.0</b>
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	16	16	0	100.0
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>32</b>	<b>32</b>	<b>0</b>	<b>100.0</b>
650006	Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	20	20	0	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	10	10	0	100.0
650010	Гэрээт ажилтан	2	2	0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>53,549,040.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>53,549,040.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>53,549,040.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>2,508,606.00</b>
210402	Тээвэр, шатахуун		200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		619,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		775,364.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		914,242.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>9,425,404.55</b>
210604	Урсгал засвар		9,425,404.55
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>40,111,272.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		39,920,052.00
210807	Газрын төлбөр		191,220.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>967,100.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		967,100.00
<b>213305</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг</b>		<b>536,657.45</b>
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>53,549,040.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>		<b>53,549,040.00</b>
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		30,000,000.00
	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		23,549,040.00



### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дүрслэх урлагийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Дүрслэх урлагийн музейн захирал П.Байгалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 26-наас 2021 оны 02 дугаар сарын 23-ны хооронд “Бизкон Аудит” ХХК-ийн аудитын баг хариуцаж хэрэгжүүлэв.

Дүрслэх урлагийн музейн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Бизкон Аудит” ХХК-д 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Дүрслэх урлагийн музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музей, түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, арвижуулах үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Ковид-19 цар тахалтай холбоотой засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэрүүд

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Дүрслэх урлагийн музей нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар 2020 онд Дүрслэх урлагийн музейн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийсэн байх бөгөөд Ковид-19 цар тахлын хөл хорионы улмаас дотоод аудитын тайлан, зөвлөмжийг ирүүлээгүй байна.

#### **3.4 Материаллаг байдал**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 639,044.6 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 12,780.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 710,258.9 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 14,205.2 мянган төгрөгөөр тооцсон.

### 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дүрслэх урлагийн музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 85,575.3 мянган төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, хуримтлагдсан үр дүн зэрэг дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	24,888.1	2,033.7	(22,854.4)
Бараа материал	80,643.5	88,137.7	7,494.2
Үндсэн хөрөнгө	27,874,413.7	27,804,198.6	(70,215.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>27,979,945.3</b>	<b>27,894,370.0</b>	<b>(85,575.3)</b>
Өр төлбөр	180.0	19.0	(161.0)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,372,812.2	2,372,812.2	-
Хуримтлагдсан үр дүн	(127,361.2)	(212,775.5)	(85,414.3)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,734,314.3	25,734,314.3	-
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>27,979,945.3</b>	<b>27,894,370.0</b>	<b>(85,575.3)</b>

Авлага дансны үлдэгдэл 2,033.7 мянган төгрөг болж 22,854.4 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд захиалсан бичиг хэрэг, ном танилцуулга мөн ажиллагсдаас авах авлага төлөгдсөнөөс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд өмнөх онуудад үүссэн, он удаан жил болсон авлага байхгүй байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй ямар нэгэн авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 88,137.7 мянган төгрөг болж 7,494.2 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх онд захиалан төлбөрийг гүйцэтгэсэн бичиг хэрэг, ном танилцуулга зэргийг тайлант онд хүлээн авсан мөн тайлант хугацаанд 852.7 мянган төгрөгийн бараа материалыг хандиваар авсан зэргээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 27,804,198.6 мянган төгрөг болж 70,215.1 мянган төгрөгөөр буурсан нь өөрийн хөрөнгөөр 17078,2 мянган төгрөгийн AR ухаалаг хөтөч, Виртуал

солюнс ХХК-ийн хандив, тусламжаар 3,000.0 мянган төгрөгийн VR төхөөрөмжүүдийг худалдан авснаар нэмэгдэж 90,293.3 мянган төгрөгийн элэгдэл тооцсоноос шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 19.0 мянган төгрөг болж 161.0 мянган төгрөгөөр буурсан нь бусад зардлын өглөг болох 180.0 мянган төгрөгийг барагдуулж тайлант хугацааны эцэст ХХОАТ-ын өглөгтэй гарснаас шалтгаалжээ.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл -212,775.5 мянган төгрөг болж 85,414.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Дүрслэх урлагийн музейн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 50,416.9 мянган төгрөгөөр буюу 8.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжийн орлого 30,000.0 мянган төгрөг байна. Энэ нь Монголын урлагийн зөвлөлөөс санхүүжүүлсэн “Үзмэрийн AR ухаалаг хөтөч” төслийн санхүүжилтийн орлогоос үүдэлтэй байна.

Нийт зардал өмнөх оноос 70,677.7 мянган төгрөгөөр буюу 11.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, нэмэгдэл урамшуулал 25,409.7 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардал 17,297.0 мянган төгрөгөөр буурсан, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж 45,723.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 21,988.4 мянган төгрөгөөр өссөн зардлууд байна.

Энэ нь тайлант хугацаанд Ковид-19 цар тахлын улмаас үйл ажиллагаа зогсонги байдалтай байснаас дээрх зардлууд буурч, УБЦТС ТӨХК-иар гэрээт ажил гүйцэтгүүлсэн, мөн “Үзмэрийн AR ухаалаг хөтөч” төслийн хэрэгжилттэй холбоотойгоор бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж өссөн байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 573,724.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 573,724.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн батлуулсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчаас санхүүжүүлэхээр 573,724.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 573,724.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 566,876.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 466,207.1 мянган төгрөгийг зарцуулж 100,669.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 466,207.1 мянган төгрөг буюу 81.3 хувьтай байгаа нь цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардлыг 73,249.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 11,717.2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ 13,722.7 мянган төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн буцалтгүй тэтгэмж 6,942.6 мянган төгрөг, үйл ажиллагааны бусад зардлыг 1,884.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого 23,549.0 мянган төгрөг, төрийн болон орон нутгийн бус өмчит этгээдээс авсан хандив, тусламжаар 30,000.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хангамж, бараа материалын зардалд 2,508.6 мянга, эд хогшил худалдан авахад 9,425.4 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрт 40,111.3 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 967.1 мянга, нийт 53,012.4 мянган төгрөгийг зарцуулж, 536.6 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлжээ.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 170 мэдээллээс хугацаандаа оруулсан 137 мэдээлэл, нийт 315,603.2 мянган төгрөгийн хугацаа хоцроосон 33 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4,237.6 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоосныг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 2,207.3 мянган төгрөгийн 4 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	4,237.6	1	4,237.6	-	-	-
Зөвлөмж	4	2,207.3	2	2,207.3	2	-	50
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>6,444.9</b>	<b>3</b>	<b>6,444.9</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>50</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

2019 оны санхүүгийн тайлангаар өгсөн аудитын 2 зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байгаад албан шаардлага хүргүүлэв. Мөн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулах тухай албан шаардлага өгсөн.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай холбоотойгоор ямар нэгэн залруулгыг хийгээгүй болно.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, 2 зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу 170 мэдээлэл оруулахаас 137 мэдээлэл хугацаандаа оруулж, 33 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-д заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” заалттай нийцэхгүй, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

2. Мөн өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө.” 20.3-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-д заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ.” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

## **Аудитын зөвлөмж**

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

### **3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд**

Дүрслэх урлагийн музейн үндсэн үйл ажиллагааны орлогыг 2020 онд Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоор бүртгэсэн тул 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Менежментийн захидал**

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөх асуудал илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<i>Дүрслэх урлагийн музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			САГ-2021/45/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дүрслэх урлагийн музей		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн (мян.төг)	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	0	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Ану
2	Шилэн дансны хуулийн дагуу 170 мэдээлэл оруулахаас 33 мэдээлэл хугацаа хоцроосон байна.	0	Албан шаардлага өгөх	Ерөнхий нягтлан бодогч	Б.Ану
<b>Нийт дүн</b>		<b>0</b>			





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 05

№ 196/А0170069

Улаанбаатар хот

СЭГ-0021/45/СТЭ-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дүрслэх урлагийн музейн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Дүрслэх урлагийн музейн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,207.3 (хоёр сая хоёр зуун долоон) мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, үүнээс 2 зөвлөмжийн хэрэгжилт хангагдаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Төрийн аудитын байгууллага аудитын дүгнэлтэд тулгуурлан төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрх зүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зорилгоор шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтанд зөвлөмж өгнө." 20.3-т "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, зөрчлийг арилган биелэлтийг 2021 оны 06 сарын 10-ний өдрийн дотор Үндэсний аудитын газар ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Дүрслэх урлагийн музейн захирал П.Байгалмаа, ерөнхий нягтлан бодогч Б.Ану нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*Ц. Наранчимэг*

Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТОР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ

*Ч. Дашдаваа*

Ч.ДАШДАВАА

Л.ОТГОНБАЯР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 195/АО170063

Улаанбаатар хот

С.ОН-0021/45/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дүрслэх урлагийн музейн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст 170 мэдээлэл байршуулахаас 33 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай" хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1- заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг ил тод, тогтоосон хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллахыг Дүрслэх урлагийн музейн захирал П.Байгалмаа, ерөнхий нягтлан бодогч Б.Ану нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:  
БИЗКОН АУДИТ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ

Ч.ДАШДАВАА

Л.ОТГОНБАЯР